

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/605, аймгийн Засаг даргын 2021 оны А/111 дүгээр захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг нэгдүгээр, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах хугацааг хоёрдугаар, холбогдох баримт бичгийн хэрэгжилтийн тайлагнах хүснэгтийг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Журмыг хэрэгжилтийг хангаж ажиллахыг харьяа байгууллагуудын дарга, захирал, Эрүүл мэндийн газрын хэлтэс, төвийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Ч.Бурмаа)- д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/52 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЛХАГВАЖАРГАЛ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль-33.5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албаны дарга эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргаж, тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын бүрэн эрх

12.1.4. харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих;

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмыг Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, Эрүүл мэндийн газар (ЭМГ)-ын харьяа лавлагаа шатлалын эмнэлэг, Зооноз өвчин судлалын төв болон сум, тосгоны Эрүүл мэндийн төв (ЭМТ) (цаашид “Эрүүл мэндийн байгууллага” гэх)-ын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ)-ний зорилго нь эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөө, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

1.3.Хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ)-ний зорилт нь:

1.3.1.Хууль тогтоомж, тогтоол, бодлогын баримт бичгүүдийн холбогдох шийдвэрүүд нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхэд үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх

1.3.2.Харьяа Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхийг үнэлж, дүгнэлт, зөвлөмж гаргах

1.3.3.Төлөвлөсөн арга хэмжээ үр дүнгүй бол түүнийг сайжруулах арга хэмжээг тодорхойлох, шаардлагатай тохиолдолд бодлогын шинэ зорилт дэвшүүлж Эрүүл мэндийн газрын зөвлөлийн хуралд танилцуулах

1.3.4.Шийдвэр гаргах үйл ажиллагааг бодлогын хувилбар, санал, дүгнэлт зөвлөмжөөр дэмжихэд чиглэгдэнэ.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. Энэ журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1.“хяналт-шинжилгээ” гэж байгууллагын үйл ажиллагаа болон бодлогын зорилго, зорилт, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцыг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянах, мэдээлэх тасралтгүй үйл ажиллагааг;

2.1.2. “үнэлгээ” гэж байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын хэрэгжилтийг төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхэд дүн шинжилгээ хийж өгсөн үнэлэлтийг;

2.1.3. “үр дүнд суурилсан явцын үнэлгээ” гэж хяналт-шинжилгээний мэдээлэлд үндэслэн зорилтот түвшинд хүрч байгаа эсэхэд үнэлгээ хийх, хүрээгүй бол шалтгаан нөхцөлийг тодорхойлж, үр дүнг сайжруулах дүгнэлт, зөвлөмж гаргах үйл ажиллагааг;

2.1.4. “үр дүнд суурилсан эцсийн үнэлгээ” гэж бодлогын баримт бичиг хэрэгжиж дууссаны дараа хэрэгжилтийг үнэлж, үр дүн, үр ашиг, үр нөлөөг тодорхойлон цаашид тухайн чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлэх, эсхүл зогсоох талаар дүгнэлт, зөвлөмж гаргах үйл ажиллагааг;

2.1.5. “хөндлөнгийн үнэлгээ” гэж бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн, байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн мэргэжлийн байгууллага, судлаач, үнэлгээчдийн хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг;

2.1.6. “хэрэглэгчийн үнэлгээ” гэж эрүүл мэндийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгааг хөндлөнгийн байгууллагаар хийлгэсэн дүнг;

2.1.7. “шалгуур үзүүлэлт” гэж бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлтийг;

2.1.8. “суурь түвшин” гэж үйл ажиллагаа болон бодлогын баримт бичиг, хэрэгжиж эхлэх үеийн шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг;

2.1.9. “зорилтот түвшин” гэж тухайн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг.

Гурав.Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим

3.1.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах зарчмыг баримтална.

3.1.1.Шударга, хөндлөнгийн нөлөөнөөс хараат бус байх

3.1.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа нээлттэй, тэдгээрээс гарсан тайлан, дүгнэлт нь ил тод байх

3.1.3.Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь шалгуур үзүүлэлт, тоо баримт судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх

3.1.4.Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан дүгнэлт нь тухайн бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг тодорхойлсон, нотлогдохуйц байх

3.1.5.Хяналт-шинжилгээг тасралтгүй, үнэлгээг тогтмол, тодорхой үе шаттай хийдэг байх

3.1.6.Хяналт-шинжилгээ үнэлгээ хийхдээ хэрэглэгч, оролцогч болон олон нийтийн оролцоог хангасан байх

3.1.7.Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгагдсан мэдээллийн үнэн зөв байдлыг холбогдох байгууллага, албан тушаалтан хариуцдаг байх

Дөрөв.Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ

4.1.Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн болон тусгайлсан ХШҮ хийнэ. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээнд дараах бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа багтана. Үүнд:

4.1.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт дараах баримт бичиг хамаарна.

4.1.1.1.Монгол Улсын хууль

4.1.1.2.Улсын Их Хурлын тогтоол

4.1.1.3.Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол

4.1.1.4.Ерөнхийлөгчийн зарлиг

4.1.1.5.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр

4.1.1.6.Засгийн газрын тогтоол

4.1.1.7.Ерөнхий сайдын захирамж

4.1.1.8.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл

4.1.1.9.Засгийн газрын болон Ерөнхий сайдын албан даалгавар

4.1.1.10.Эрүүл мэндийн сайдын тушаал, албан даалгавар

4.1.1.11.Аймгийн ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн тогтоол

4.1.1.12.Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар

4.1.1.13.Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын тушаал, албан даалгавар

4.1.2.Бодлогын баримт бичигт дараах баримт бичиг хамаарна.

4.1.2.1.Төрөөс баримтлах бодлого

4.1.2.2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр

4.1.2.3.Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

4.1.2.4.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр

4.1.2.5.Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө

4.1.3.Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг дараах үзүүлэлтүүдээр дүгнэнэ.Үүнд:

4.1.3.1.Энэхүү журмын 4.1.1, 4.1.2-т заасан баримт бичгийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

4.1.3.2.Төсвийн шууд захирагч Эрүүл мэндийн байгууллагын /НЭ, УАУНЭ, ЗӨСТ-ийн/ дарга нартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

4.1.3.3.Сумын Засаг дарга Эрүүл мэндийн байгууллагын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

4.1.3.4.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт

4.1.3.5.Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт, үүнд:

4.1.3.5.1.Үйл ажиллагааны ил тод байдал

4.1.3.5.2.Хүний нөөцийн ил тод байдал

4.1.3.5.3.Шилэн дансны хөтлөлт

4.1.3.6.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт

4.1.3.7.Хэрэглэгчийн үнэлгээний тайлан

4.1.3.9.Хариутай бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

4.2.1.Гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ нь энэхүү журмын 4.1.3-т заасан баримт бичгийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа хамарна.

4.2.2.Тусгайлсан хяналт-шинжилгээ, үнэлгээ нь дараах хүрээг хамарна.

4.2.2.1.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ:

4.2.2.1.1.Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн

4.2.2.1.2.Эмнэлзүйн удирдамж, зааврын хэрэгжилтийн байдал

4.2.2.1.3.Зайлшгүй шаардлагатай болон амин чухал эмийн хангамж, эмийн чанар, аюулгүй байдал, эмийн зохистой хэрэглээ

4.2.2.1.4.Эмчилгээ, оношилгооны шинэ арга, дэвшилтэт технологийг практикт нэвтрүүлж, эрүүл мэндийн болон эдийн засгийн үр дүнг тооцсон байдал

4.2.2.1.5.Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүн

4.2.2.1.6.Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой гомдлын шийдвэрлэлт

4.2.2.1.5.Нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаарх холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн байдал, үр дүн

4.2.2.2.Байгууллагын удирдлага, хөгжил:

4.2.2.2.1.Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн

4.2.2.2.2.Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн

4.2.2.2.3.Болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, онцгой байдлын үеийн бэлэн байдал хангах, хариу арга хэмжээний болон нөхөн сэргээх үеийн төлөвлөгөө, хэрэгжилтийн байдал

4.2.2.2.4.Байгууллагын эрсдлийн удирдлага, эрсдэл бууруулах төлөвлөгөө хэрэгжилтийн байдал

4.2.2.2.5.Тухайн байгууллагаас хэрэгжүүлж буй судалгааны хэрэгжилт календарчилсан төлөвлөгөөний биелэлт;

4.2.2.2.6.Байгууллагын гадаад хамтын ажиллагаа, гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж буй төслийн үр дүн;

4.2.2.2.7.Байгууллагын хөгжил, соёлын талаарх холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн байдал, үр дүн

4.2.2.2.8.Байгууллагын даргын тушаалын эрх зүйн үндэслэл

4.2.2.2.9.Байгууллага дах багуудын үйл ажиллагааны үр дүн

4.2.2.2.10.Харьяалах дээд байгууллагаас өгсөн зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилт

4.2.2.3.Хүний нөөцийн хөгжил:

4.2.2.3.1.Эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй сургалтад хамруулах төлөвлөгөөний хэрэгжилт

4.2.2.3.2.Төгсөлтийн дараах сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн (дотоод, гадаадын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлийн тоо төгсөлтийн дараах сургалт явуулж буй мэргэжлийн чиглэл, суралцагсдын тоо г.м.)

4.2.2.3.3.Байгууллагын ажилтны нөөц бүрдүүлэлт, нөөцөөс авсан ажилтны тоо

4.2.2.3.4.Ажлын байрны тодорхойлолтыг хэрэгжүүлсэн байдал

4.2.2.3.5.Ажиллагсдын нийгмийн баталгаа, ажиллах нөхцлийг сайжруулах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн

4.2.2.3.6.Ажлын байран дээрх осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэх талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, ажиллагсдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байдал

4.2.2.3.7.Хүний нөөцийн талаарх холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн байдал, үр дүн

4.2.2.4.Санхүүгийн удирдлага:

4.2.2.4.1.Төсвийн гүйцэтгэл, өр, авлагын хэмжээ

4.2.2.4.2.Төсөв, санхүүгийн ил тод байдал

4.2.2.4.3.Аудит болон санхүүгийн эрх бүхий байгууллагаас тогтоосон акт, албан даалгаврын хэрэгжилт, эргэн тайлагналт

4.2.2.4.4.Нягтлан бодох бүртгэл, төсвийн удирдлага, санхүүжилтийн талаарх холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн байдал, үр дүн

4.2.2.4.5.Эрүүл мэндийн даатгалын хамралт, санхүүжилтийн талаарх холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүн

4.2.2.4.6.Албан бус төлбөрийг бууруулах арга хэмжээний үр дүн

4.2.2.4.7.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдал

4.2.2.5.Мэдээллийн удирдлага:

4.2.2.5.1.Статистик мэдээллийн үнэн бодит, шуурхай байдал, мэдээний чанар

4.2.2.5.2.Байгууллагын цахим хуудасны тогтмолжсон байдал

4.2.2.5.3.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд мэдээллийн технологийн зохистой хэрэглээг төлөвшүүлсэн байдал, цахим мэдээллийн системүүдийн учлдаа холбоо, үр дүн

4.2.2.5.4.Эрүүл мэндийн мэдээлэл, мэдээллийн технологийн талаарх холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн байдал, үр дүн

Тав.Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлага, зохион байгуулалт

5.1.Эрүүл мэндийн газар нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, харьяа байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж, дүгнэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэх үүргийг хариуцна.

5.2.Захиргаа, хүний нөөц, дотоод ажил хариуцсан нэгж /Эрүүл мэндийн газарт Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс/ бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

5.3.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, мэдээлэх үүргийг тухайн байгууллагын дарга, захирал бөгөөд биелэлтийг Эрүүл мэндийн газарт ирүүлэх үүргийг хүлээнэ.

5.4.Төрийн албан хаагч бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв бодитой гаргаж өгөх үүрэгтэй.

5.5.Хяналт-шинжилгээ, үнэлгээний бүтэн жилийн дүнг байгууллагын удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсны үндсэн дээр аймгийн Эрүүл мэндийн газарт ирүүлнэ.

Зургаа.Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөлт, төрөл

6.1.1.Эрүүл мэндийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө нь хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн төлөвлөгөө байна.Төлөвлөгөөнд зорилго, зорилт, хамрагдах байгууллага, нэгж, хэрэгжүүлэх хугацаа, зардал, хамтран оролцох байгууллага зэргийг тусгана.

6.1.2.Хяналт-шинжилгээг байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцыг хянах, мэдээлэх зорилгоор тасралтгүй хийнэ.

6.1.3.Үнэлгээний зорилгоос хамааруулан үр дүнд суурилсан явцын болон эцсийн үнэлгээ хийх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөнд ямар төрлийн үнэлгээ хийх талаар нарийвчлан тусгана.

6.1.4.Хөндлөнгийн үнэлгээг явцын болон эцсийн үнэлгээний аль ч шатанд хийж болох бөгөөд иргэд, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

6.1.5.Холбогдох бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэх үүргийг эрүүл мэндийн байгууллагад тэдгээрийн дарга, захирал нар хариуцна.

Долоо.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

7.1.Гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ, үнэлгээг Эрүүл мэндийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь бусад хэлтэсүүдтэй хамтарч хийнэ.

7.2.Тусгайлсан хяналт-шинжилгээ, үнэлгээг эрүүл мэндийн байгууллагуудын жилийн үйл ажиллагаанд эсхүл бодлогын тодорхой чиглэлээр хийнэ. Хамрах хүрээ, хугацааг удирдамжаар тодорхойлно.

7.3.Энэхүү журмын 4.2.2.1, 4.2.2.2, 4.2.2.3, 4.2.2.4, 4.2.2.5-д заасан тусгайлсан ХШҮ-г Эрүүл мэндийн газрын хэлтэсүүд шаардлагын дагуу хийж гүйцэтгэнэ.

7.4.Эрүүл мэндийн газраас жилд 8-аас доошгүй Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд энэхүү журмын 6.2.-т заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг Эрүүл мэндийн газрын зөвлөлийн хуралд танилцуулна.

7.5.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээ, хугацаа, удирдамжийг Эрүүл мэндийн газрын дарга батална.

7.6.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Эрүүл мэндийн газрын даргын удирдамж, энэхүү журмыг үндэслэл болгоно.

7.7.Хяналт шинжилгээ, үнэлгээг хийхдээ холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтарсан баг байгуулж болно.

7.8.Зайлшгүй шаардлагаар Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжаар бодлогын тодорхой чиглэлээр төлөвлөгөөт бус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж болно.

7.9.Гүйцэтгэлийн болон тусгайлсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын хэсгийн ажиллах хэлбэр нь хурал байна. Хурлаас тэмдэглэл гарах бөгөөд уг тэмдэглэлд хуралд оролцогчид, гишүүдийн ирц, хэлэлцэх асуудлын агуулга

асуудлыг хэлэлцсэн явц болон хурлаас гарсан шийдвэрийг тус тус тусган, хуралд оролцсон гишүүдийн гарын үсгийг зурж баталгаажуулна.

7.10.Ажлын хэсгийн хурлыг нийт гишүүдийн дийлэнх олонхи оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцож, ердийн олонхийн саналаар шийдвэр гаргана.

7.11.Эрүүл мэндийн салбараар үйлчлүүлж буй хэрэглэгчийн сэтгэл ханамжийн нэгдсэн үнэлгээг жилд 1-ээс доошгүй удаа Эрүүл мэндийн газар зохион байгуулах бөгөөд эрүүл мэндийн байгууллагуудыг хамруулан явуулсан санал асуулгын үнэлгээг шууд хэрэглэнэ.Эрүүл мэндийн газар нь энэхүү зорилгоор судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажилладаг мэргэжлийн болон төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулж судалгааг гүйцэтгүүлж болно.

Найм.Үйл ажиллагааны тайланд тавигдах шаардлага

8.1.Үйл ажиллагааны тайланд дурьдсан тоо баримт, хүрсэн үр дүн мэдээллүүд нь үнэн зөв байна.Тоо баримт мэдээ үнэн зөв эсэхийг тайланд гарын үсэг зурсан албан тушаалтан бүрэн хариуцна.

8.2.Тухайн жилийн үйл ажиллагааны үр дүн, зорилтыг дэвшүүлэх үеийн үр дүнтэй харьцуулан дүгнэсэн байхын зэрэгцээ тайланд дурьдсан тоо баримт статистик мэдээллийн судалгаатай нийлж байх шаардлагатай.

8.3.Үйл ажиллагааны үр дүнгийн тайланд байгууллага тайлант хугацаанд ямар зорилт дэвшүүлж ямар үр дүнд хүрэв гэдгээ ойлгомжтой товч тодорхой бичсэн байна.

8.4.Зорилтод түвшинд хүрээгүй тасалдаж байгаа бол шалтгааныг тодорхой дурьдаж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар саналаа тайланд тодорхой тусгасан байх шаардлагатай.

8.5.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагааны тайлангийн холбогдох зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүн буюу биелэлтийг бичихдээ хоёр мянган тэмдэгтэд багтаана.

8.6.Тайлангийн төгсгөлд тайланг нэгтгэн гаргасан албан тушаалтан, тайланг хянасан байгууллагын дарга хоёр нэр албан тушаалаа бичиж гарын үсгээ зурж баталгаажуулсан байна.

Ес.Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй:

9.1.Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дараахь аргачлалын дагуу хувиар илэрхийлэн үнэлнэ.

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} \cdot 100\%$$

9.2.Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг тодорхойлоход дараахь аргачлалаар тооцно.

9.2.1.зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь

9.2.2.тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол 70.0 хувь

9.2.3.тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол 50.0 хувь

9.2.4.тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол 30 хувь

9.2.5.тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийг “0” хувь.

9.3.Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг энэ журмын 7.1, 7.2-т заасан аргачлалын дагуу тооцож, зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцно.

9.3.1.“үр дүнтэй”- зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур

үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь

9.3.2.“тодорхой үр дүнд хүрсэн”-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70-99 хүртэл хувь

9.3.3.“эрчимжүүлэх шаардлагатай”-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл

ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай бол 31-69 хүртэл хувь

9.3.4.“үр дүнгүй”-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай,

шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0-30 хүртэл хувь

9.4.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийн үнэлгээг дараах аргачлалаар тооцно.

9.4.1.“бүрэн хэрэгжсэн”-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь)

9.4.2.“хэрэгжих шатанд”-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь (50-89 хүртэл хувь)

9.4.3.“хэрэгжилт хангалтгүй”-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй бол 30 хувь (10-49 хүртэл хувь)

9.4.4.“хэрэгжээгүй”-тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, бэлтгэл ажил хийгдэж боловсруулалтын шатанд байгаа болон тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 хувь (0-9 хүртэл хувь)“

9.4.5.хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”

9.5.Бодлогын зорилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн ерөнхий дүнг гаргахдаа арга хэмжээ, зүйл, заалт бүрийн хэрэгжилтийн арифметик дунджаар тооцно. Тавьсан зорилтын арга хэмжээ, шийдвэрийн зүйл, заалтын гүйцэтгэлийн үр дүнг хүрэх түвшин буюу тавьсан зорилтод харьцуулж хувиар илэрхийлнэ.

9.6.Эрүүл мэндийн байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн үнэлгээний дүнг гаргахдаа үзүүлэлт бүрийн үнэлгээг 100 хүртэл хувиар илэрхийлэн нийлбэр үнэлгээний арифметик дунджийг харгалзах жинд шилжүүлнэ. Ерөнхий үнэлгээг тодорхойлохдоо жинд шилжүүлсэн дүнгүүдийн нийлбэрийг 0.05-аар үржүүлж, 0-5 хүртэл оноонд шилжүүлэн дүгнэнэ.

Е- ерөнхий үнэлгээ

а-бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хувь

β-байгууллагын чиг үүргийн биелэлтийн хувь

γ-байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ

μ-эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийн хувь

t- хэрэглэгчийн үнэлгээ

$$E=0.05*[a*0.2+ \beta *0.3+ \gamma *0.1+ \mu *0.3+ t*0.1/]$$

9.7. Стратеги төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ бодлогын баримт бичиг үнэлэх аргачлал, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт, байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үнэлэхдээ хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээг тооцдог аргачлалыг тус тус баримтална.

9.8. Хэрэгжилтийн тайланг дээд шатны байгууллагад тайлагнахдаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын гүйцэтгэл, үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаана.

9.9. Эрүүл мэндийн байгууллагууд дотооддоо жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний танилцуулга, дүнг байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хурлаас гарсан дүгнэлт, зөвлөмжийг Эрүүл мэндийн газрын ХШҮ-ний нэгжид ирүүлнэ.

9.10. Ерөнхий үнэлгээний оноог үндэслэн дор дурьдсан үнэлгээний аль нэгийг өгнө. Үүнд:

“А” буюу “Маш сайн”	90-100 хувь (4.50-5.00 оноо)
“В” буюу “Сайн”	80-89.0 хувь (4.00-4.49 оноо)
“С” буюу “Хангалттай”	70-79.0 хувь (3.50-3.99 оноо)
“D” буюу “Дутагдалтай”	60-69.0 хувь (3.00-3.49 оноо)
“F” буюу Хангалтгүй	0-59.0 хувь (0.00-2.99 оноо)

Арав. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

10.1. Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны зорилго нь баримт бичгийн төлөвлөлт, биелэлтэд чанарын үнэлгээ хийх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, үр нөлөөг үнэлэхэд оршино.

10.2. Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд дараахь үе шатаар цогц хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ:

10.2.1. мэдээллийг цуглуулах, ангилах, нэгтгэх;

10.2.2. зорилтын биелэлтийн дүнг үнэлэх;

10.2.3. биелэлтийн үр нөлөөг үнэлэх;

10.2.4. гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллийг үнэлэх;

10.2.5. төлөвлөлт, хэрэгжилтийн харилцан хамаарлыг үнэлэх;

10.2.6. биелэлтийн түвшинг үнэлэх;

10.2.7. бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах тодорхой санал боловсруулах.

10.3. Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу энэ журмын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалаар үнэлнэ.

10.4. Шаардлагатай тохиолдолд харьяалах дээд шатны байгууллага нь бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг газар дээр нь шалгаж, тайланг хэлэлцэн түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авна.

10.5. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг журмын 2-3 дугаар хавсралтын дагуу гаргаж, тайланг 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлнэ.

Арван нэг. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

11.1. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хяналтад авч, хэрэгжилтийг салбар, чиглэлээр ангилан журмын 5 дугаар хавсралтын дагуу гаргаж тайланг 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд холбогдох хэлтэст хүргүүлнэ.

11.2. Эрүүл мэндийн байгууллагууд нь хууль тогтоомж, тогтоол шийдвэр, тэдгээрт нийцүүлэн гаргасан шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах бөгөөд хэрэгжилтэд нь Эрүүл мэндийн холбогдох хэлтэс хяналт тавьж тайлагнана.

11.3. Эрүүл мэндийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс нь хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн нэгдсэн дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулах бөгөөд хурлаас гарсан шийдвэрийг холбогдох хэлтэс, байгууллага мөрдөж ажиллана.

11.4. Бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон сүүлийн 3 жил тасарсан болон тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн заалтыг хүчингүй болгох, хяналтаас хасах тухай саналыг жилийн эцсийн тайлангийн хамт Эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.

11.5.Шаардлагатай гэж үзвэл нь Эрүүл мэндийн газрын ХШҮ-ний нэгж нь хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг агуулга, чиглэлээр нь багцлан хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэн хэрэгжилтийг газар дээр нь шалгаж, тэдгээрийн мөрөөр холбогдох арга хэмжээг авна.

Арван хоёр.Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

12.1.Эрүүл мэндийн байгууллага нь тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг энэхүү тушаалын 3 дугаар хавсралтын хүснэгт 3.5-3.8-ын дагуу гаргаж, тайланг Эрүүл мэндийн газрын холбогдох хэлтэст хавсралтад дурьдсан хугацаанд хүргүүлнэ.

12.2.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг Эрүүл мэндийн газрын Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтэс гаргаж ХШҮ-ний нэгжид 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хүргүүлнэ.

12.3.Эрүүл мэндийн байгууллагын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн ХШҮ- ний дүнг Эрүүл мэндийн газрын байгууллагын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

Арван гурав.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

13.1.Эрүүл мэндийн газрын зөвлөлийн хурлаас байгууллагуудын үйл ажиллагааг дүгнэн байр эзлүүлж хамгийн өндөр оноо авсан дарааллын дагуу 3 байгууллагыг **Эрүүл мэндийн газрын даргын Хүндэт өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.-/1 сая төгрөг эсвэл 500000 мянган төгрөг/**

13.2.Гүйцэтгэлийн үнэлгээний дүнгээр тэргүүлсэн болон “Маш сайн” үнэлгээ авсан эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтанг цалин нэмэх, гадаад улсад сургалт, танилцах аялалд хамруулах, салбарын шагналаар шагнах, төрийн одон, медальд нэр дэвшүүлэх, удирдаж буй байгууллагын үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн төсөл хэрэгжүүлэх эрх олгох зэргээр урамшуулна.

13.3.Үнэлгээний дүнгээр “Сайн” гэж дүгнэгдсэн бол байгууллагын удирдлагад холбогдох хууль тогтоомжийн дагуу урамшуулах саналыг хүргүүлнэ.

13.4.Урамшуулалд шаардагдах хөрөнгийг Эрүүл мэндийн газар төсөвтөө жил бүр тусгана.

13.5.Эрүүл мэндийн газар нь тэргүүлсэн байгууллагуудын тэргүүн туршлага, аргыг түгээн дэлгэрүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтийн хүртээл болгоно.

13.6.Эрүүл мэндийн газар нь харьяа байгууллагуудын тухайн жилийн үйл ажиллагааны нэгдсэн үнэлгээг гаргахдаа шаардалгатай гэж үзсэн тохиолдолд ажлын хэсэг байгуулан газар дээр нь очиж ажиллан үнэлнэ.

